



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот


“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн  
үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ-ын  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 29,880,000 (хорин есөн сая найман зуун наян мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ (Б.Мягмар)-т зөвшөөрсүгэй.


2.Данснаас хасагдаж буй нийт 29,880,000 (хорин есөн сая найман зуун наян мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөхийг “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк” ОНӨТҮГ (Б.Мягмар)-т, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт дотоод аудитын хэлтэст үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.



ДАРГА ~~М.БАЯРАА~~

Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын  
 2022 оны 02 дугаар сарын 01 ны өдрийн  
 9/21 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк" ОНӨТҮГ

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
<b>Нийтийн эзэмшлийн барилга байгууламжийн нэр</b>										
1	2*3 м төмөр торон хашаа	2016	ш	90	332,000	29,880,000	29,880,000	0	эвдэрхий	татах
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>						<b>29,880,000</b>				
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Устгах хөрөнгө										
Татан авах										
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх 30%										